

**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ҮЙЛДВЭРИЙН АЛБАНЫ АШИГЛАЛТЫН ХЭСГИЙН
ЗУУХАН ЦЕХИЙН ГОРИМЫН МАШИНЧИЙН
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

А. “АЖЛЫН БАЙРНЫ ТАНИЛЦУУЛГА”

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:	
“Багануурын дулааны станц” ТӨХК	Үйлдвэрийн алба	
Ажлын байрны нэр:	Ангилал	Зэрэглэл
Зуухан цехийн горимын машинч	Ажилтан	Хэвийн бус
Шууд харъяалагдах ажлын байрны /албан тушаал/	Шууд харъяалах ажлын байрны /албан тушаал/	
Ашиглалтын инженер		
Орлон ажиллах албан тушаалтан	Сүлжээний насосны ээлжийн машинч	

Б. АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	Дулаан үйлдвэрлэх, Сүлжээний усны t ⁰ С-ын горим барьж ажиллах
2. Ажлын байрны үндсэн чиг үүрэг	<p>1.Усан халаалтын зуухнуудын үндсэн болон туслах тоноглолын хэвийн ажиллагаа бүрэн бүтэн байдлыг шалгах, зуухыг засварт өгөх, засвараас хүлээж авах, хэвийн ажиллагааг хангаж ажиллах.</p> <p>2.Зуухыг галлах, зогсоох, сүлжээний ус халаах</p> <p>3.ТАД, ААД, ГАУСД, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм стандартыг мөрдөж ажиллах</p> <p>4.Зуухнуудын ТЭЗҮ-г дээшлүүлэх, арвилан хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлж ажиллах.</p>
3. Ажлын байранд хийгдэх үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Өөрийн хариуцсан усан халаалтын зуухнуудад үзлэг шалгалтыг хийж, 2 цаг тутам хариуцсан удирдлагадаа мэдэгдэж байх • Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, биелэлтийн талаар эргэж мэдэгдэж байх • Ээлж хүлээлцэх, ээлжинд ажиллах болон бусад дүрэм, журам, зааврыг биелүүлж, хяналт тавьж ажиллах • Зуухны тооцооны хэмжүүрүүдийн ажиллагаанд хяналт тавьж, тооцоологдсон хүчин чадалд хүргэж ажиллуулах • Дулааны горим барих ажилтай холбогдсон усны даралт, зарцуулалт, температурын горим ажиллагааны тохируулга хийх • Зуухны үндсэн болон туслах тоноглолын залгалт, салгалтыг удирдлагаас авсан шийдвэрийн дагуу хийж гүйцэтгүүлэх • Ашиглалтад байгаа болон бэлтгэлд байгаа тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд байнга хяналт тавьж ажиллах • Засварт гарах тоноглолыг цэвэрлэж, ажлын байр бэлдэж засварт хүлээлгэн өгөх. • Засвараас гарч байгаа тоноглолыг зангилаа тус бүрээр нь эргэх механизмыг нэг бүрчлэн явуулж хүлээж авах. • Зуух шлакдах үед зуухыг бүрэн хөргөж усаар норгох, ДС- ыг явууж, ам нээлхийг онгойлгож агааржуулсны дараа орж цэвэрлэх. • Зуухны технологийн болон блокировка хамгаалалт тавигдсан

байх, зуухны үе нэмэгдэх, багасах тохиолдлыг байнга хяналт тавьж ажиллах.

- Зуухны үе нэмэгдсэн тохиодолд үе шиберь татаж буулгахдаа нүүрний хамгаалалт өмсөж түлэгдэхээс болгоомжлох.
- Зуухны үе багасах тохиолдолд зуухны ачаалал багасгаж, ДС – ыг дарж ураш үлээхгүй болсон үед үе нэмж хийх
- Зуухнуудын утааны хоолой, циклон, яндангийн үнс цэвэрлэх.
- ГЗУ –н ф-180, ф-1000 –н резевуар, гадна худаг лайдах.
- “С” цэг болон уурхайгаас хаяж буй хар усны шугам хөлдсөн үед /халуун тогоо/ галлаж уураар үлээлгэж гэсгээн гаргаж ажиллах.
- Зуухны инертийн материал /элс хайрга/ татах.
- Станцын цонх болон барилгын ажилд туслан гүйцэтгэгчээр ажиллах.
- Наряданд заагдсаны дагуу ажлын байр бэлдэх, засварт хүлээлгэн өгөх журмын дагуу хүлээлгэн өгч, туршилтын хугацаанд тухайн тоноглолыг ажиллуулан хүлээн авах ажлыг гүйцэтгэх
- Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад өөртөө болон бусад ажилчдын аюулгүй ажиллагаа, эрүүл мэндэд онцгой анхаарч осолгүй ажиллах үүрэг хүлээж ажиллах
- Зуухны даралт, зарцуулалт, температурт хяналтыг байнга тавьж, зуухны үндсэн болон туслах тоноглол, техникийн байдлаас шалтгаалсан аваарь ослоос сэргийлж ажиллах
- Зуухны хоногийн үзүүлэлтийг хөтлөн ажиллах
- Шуурхай ажиллагааны зуухны машинчийн хөтлөх журналд ээлжийн бүхий л хугацаанд эргэлт шалгалт хийсэн, үүрэг даалгавар авсан, тоноглолын ажиллагааны байдлын талаар нэг бүрчлэн үнэн зөв, гаргацтай бичиж тэмдэглэх
- Өөрийн хариуцсан тоноглолд ТАД, ААД, ГАУСД-ийн зөрчил илэрсэн тухай бүр удирдлагадаа мэдэгдэж зохих ёсны арга хэмжээг зааварчилгааны дагуу авах, шаардлагатай тохиолдолд арилгуулах арга хэмжээг авах
 - Удирдах ажилтан ажлын байраар явахад өөрийн хариуцсан тоноглолын ажиллагааны байдлын талаар мэдээлэл, рапорт өгөх

В. “АЖЛЫН БАЙРНЫ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР”

Хувь хүний сахилга бат, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байх.

Компанийн дотоод зохион байгуулалт, нэгдсэн арга хэмжээ үйл ажиллагаанд бүрэн оролцох.

Үйлдвэрлэлийн найдвартай, жигд, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллахад оролцох.

Хариуцсан үүрэгт ажлаа цаг тухайд нь чанартай сайн гүйцэтгэж, тоноглолын ажиллах цагийг уртасгах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд шинийг санаачилж ажиллах

Үйл ажиллагаандаа ХАБЭА, ТАД, ААД болон холбогдох дүрэм, журам, зааварчилгаануудыг мөрдлөг болгон ажилласан байх

Баг хамт олонд зөв уур амьсгал бүрдүүлж, эерэгээр нөлөөлөх.

Хамтран ажиллагсадтайгаа соёлтой, боловсон харьцах

Ашиглаж буй компанийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт

тавьж, зохих арга хэмжээг авч ажиллах.

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажиллах.

Г. “АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА”

Ажлын байранд тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага	Боловсрол	Тусгай дунд боловсролтой
		Мэргэжил	Зуухан цехийн горимын машинч
		Мэргэшил	
		Туршлага	Мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан байх
	Ур чадвар	Орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, Бичгийн болон зургийн чадвартай ➤ Гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвар <ul style="list-style-type: none">• Дасан зохицох• Санаачилгатай байх• Багаар ажиллах	
Тусгай шаардлага		➤ Ёс зүйн хэм хэмжээг сахих, байгууллагын нууц хадгалах. ➤ Орлон ажиллах чадвартай байх	

Д. “ШИЙДВЭР ГАРГАХ ЭРХ МЭДЭЛ”

Шийдвэр гаргах асуудал	Эрхийн хэмжээ
Хариуцсан ажлын хүрээнд	

Е. “АЖИЛ ЭРХЛЭГЧДИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА”

Ажлын үр дүнгийн талаар ажил эрхлэгчдийн хүлээх хариуцлага	Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрчим хүчний салбарт мөрдөгдөж буй хүчин төгөлдөр дүрэм журам, компанийн хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.
	Санаатай болон болгоомжгүй хайхрамжгүй үйлдлийн улмаас өөрийн болон бусдын биед, байгууллагын өмч хөрөнгөд хохирол учруулсан, гэмтээсэн, үрэгдүүлсэн, алдсан тохиолдолд сахилгын, захиргааны болон эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.
	Үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаануудыг мөрдөж ажиллаагүй тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.
	Ажлын цаг ашиглалт сул, таслалт, хоцролттой тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.
	Ажилтан ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, дутагдал, зөрчил гаргасан, хариуцлага алдсан тохиолдолд холбогдох хууль, дүрэм,

журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.

Ажилтны ажлын эцсийн үр дүнг шууд болон шугаман удирдлага хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх ба хангасан тохиолдолд холбогдох гэрээ, журмын дагуу шагнал урамшуулал тооцож болно.


Ё. “АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ, АЖЛЫН ХЭРЭГСЭЛ”

Ажлын байрны нөөц, хэрэгсэл	ҮАлба	Батлагдсан үндсэн цалин болон нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал.
	Эд хөрөнгө	Эд хөрөнгийн бүртгэлийн картанд бүртгэгдсэн биет хөрөнгө
	Хүн, хүч	-Хэсгийн болон бусад ажилчид
	Хувь хүний хөгжил	Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж, гарын авлага, бусад зүйлээр хангагдсан, шинээр байнга суралцахыг эрмэлзэх.
Ажлын байрны нөхцөл		Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллана.

Ж. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг хянасан эрх бүхий албан тушаалтан:	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан:
АЛБАН ТУШААЛЫН НЭР: ХЯНАСАН: “БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭРИЙН АЛБАНЫ ДАРГА (Л.ГАНТӨГС) (Гарын үсэг)	АЛБАН ТУШААЛЫН НЭР: “БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ (Н.ГАНБААТАР) (Гарын үсэг)
20.....оны ... дүгээр сарын ... өдөр	20..... оны ... дүгээр сарын ... өдөр

4. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТТОЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

Зуухан цехийн горимын машинч		/Э.Наранбат/
	(Гарын үсэг)	
20..... оны ... дүгээр сарын ... өдөр		